



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/108

Улаанбаатар хот

**Улсын аварга шалгаруулах Цэрэг-спортын "Дөл"
цогцолбор тэмцээнд оролцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд 2025 оны 06 дугаар сарын 05-аас 07-ны өдрүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор, зохион байгуулагдах Батлан хамгаалахын сайдын нэрэмжит Улсын аварга шалгаруулах Цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнд дүүргийн аварга ерөнхий боловсролын 91 сургуулийн "Очтон" багийн бэлтгэлийг ханган, хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлыг хангаж оролцуулахыг Цэргийн штаб (Хурандаа Ш.Бат-Өлзий)-т, Боловсролын хэлтэс (Ш.Баасансүрэн)-т, Эрүүл мэндийн төв (Х.Ганбат)-д, Биеийн тамир Спорт хороо (Г.Тэмүүлэн)-д, Соёлын ордон (Б.Алтанцоож)-д, Ерөнхий боловсролын 91 дүгээр сургууль (Э.Соёмбобат)-д тус тус үүрэг болгосугай.

2.Цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээний бэлтгэлийг хангах, оролцох албан тушаалтан баг тамирчдын нэрсийн жагсаалтыг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Үйл ажиллагаанд шаардагдах 3,600,000 (гурван сая зургаан зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг дүүргийн Засаг даргын орлогч(Х.Цогцэцэг)-д, үйл ажиллагааг зохион байгуулсан талаар холбогдох байгууллагуудад хүргэж ажиллахыг Цэргийн штаб (Хурандаа Ш.Бат-Өлзий)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн
А/108 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



ЦЭРЭГ-СПОРТЫН "ДӨЛ" ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙГ
ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Баг тамирчдын хоолны зардал	15 хүн-8 хоног	30.000	3,600,000
Нийт дүн				3,600,000